



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХК-ийн “Хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгал”-ын бүтээгдэхүүнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн бүртгэсүгэй.
2. Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэн бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Ард даатгал” ХК /Г.Цогбадрах/-д үүрэг болгосугай.
3. Хавсралтад дурдсан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Ард даатгал” ХК /Г.Цогбадрах/, актуарч /Г.Ариунжаргал/-д тус тус анхааруулсугай
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 11 сарын 16 өдрийн
330-р тогтоолын хавсралт

Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Ард даатгал” ХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Хурдан морины уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Гэнэтийн осол эмчилгээний даатгал
4.	Даатгалын зүйл	Хүүхдийн амь нас, эрүүл мэнд
5.	Даатгалын эрсдэл	1. Үндэсний баяр наадмын хурдан морины уралдааны болон бэлтгэл, сунгааны үе; 2. Гэрээний 5.1.1-д зааснаас бусад хурдан морины уралдаан, бэлтгэл, сунгааны үед учирч болзошгүй гэнэтийн осол, бэртэл гэмтэл; 3. Гэрээний хугацаанд учирч болзошгүй ахуйн осол, гэмтэл.
6.	Даатгалын гэрээний хугацаа	Харилцан тохиролцоно
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	7 бүлэг, 68 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	“Ард даатгал” ХК-ийн гүйцэтгэх хорооны хурлын 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн шийдвэр.
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Г.Ариунжаргал
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Эрсдэлийн шинжээч Б.Нямдэлгэр